



АРХАНГАЙ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2018/03



www.nso.mn www.arkhangai.nso.mn www.1212.mn




ЭРҮҮЛ МЭНД

Эмнэлгийн байгууллагууд 519 ор, амбулаторийн 111 их эмчтэйгээр хүн амд үйлчилж давхардсан тоогоор 81,9 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсний 28,0 мянгад нь урьдчилан сэргийлэх үзлэг хийж 5,7 мянган хүнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж гаргасан байна.

Вакцинжуулалтанд хамрагдвал зохих 0-2 насны хүүхдийн 98,8 хувийг бүрэн хамруулсны дотор Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан, Цэнхэр сумд 100,0 хувь хамруулсан байна.

Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 3 сарын байдлаар



Оны эхний 3 сард 459 эхээс 458 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 5,0 хувиар буюу 24 хүүхдээр бага байна,

Хүн амын нас баралт 137 гарсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 40 тохиолдлоор буюу 41,2 хувиар их байна. Мянган хүнд ноогдох төрөлт 4,8 , нас баралт 1,4 ноогдож хүн амын

ердийн цэвэр өсөлт 3,4 промил байна. Төрөхийн улмаас эндсэн эхийн эндэгдэл 1 гарч, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 1, нялхсын буюу 0-1 насны хүүхдийн нас баралт 9 гарч мянган амьд төрөлтөд 19,6 ногдож байна.

Эндсэн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 3 сарын байдлаар



Аймгийн дүнгээр арван мянган хүн тутмаас 13 нь буюу 123 хүн халдварт өвчнөөр өвчилсөн байгаа бөгөөд Батцэнгэл(26), Эрдэнэбулган(24), Булган (22), Ихтамир (27), Өндөрүлаан (21), сумдад аймгийн дунджаас дээгүүр бусад сумдад аймгийн дунджаас доогуур байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 29,3 хувь нь салхин цэцгээр, 34,1 хувь нь бэлгийн замын халдварт өвчнөөр, 13,8 хувь нь сүрьеэгээр, 22,8 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилсөн байна. Халдварт өвчний гаралт өнгөрсөн оны мөн үеийн түвшинд байна.



АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР

4 дүгээр сарын 1-ний байдлаар хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 1431 ажилгүй хүн байгаагийн 50,6 хувь нь буюу 724 нь эмэгтэйчүүд байна.

Хөдөлмөрийн насны 10,0 мянган хүн тутамд 247 ажилгүйчүүд ноогдож байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 21,0 хувиар багассан байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 98,3 хувь нь боловсролтой иргэд байгаагийн 257 нь дээд, 65 нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 1027 нь бүрэн болон бүрэн бус дунд, 58 нь бага боловсролтой хүмүүс байна.

3 дугаар сард ажилгүйчүүдийн бүртгэлд 153 хүн шинээр бүртгүүлж, 147 хүн ажил идэвхитэй хайхаа больсноос идэвхигүй болж 6 хүн ажилд зуучлуулан орсон байна.

Оны эхний 3 сард аймгийн дүнгээр 103 ажлын байр шинээр бий болгосон байна. Шинэ ажлын байрыг сумдаар үзвэл Эрдэнэбулган сум 97, Цэнхэр сум 6 ажлын байрыг бий болгожээ.



НИЙГМИЙН ДААТГАЛ ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого оны эхний 3 сард 12,6 тэрбум төг, зарлага 12,1 тэрбум төг болж өмнөх оныхоос орлого 737,9 сая төг буюу 6,2 хувиар, зарлага 811,1 сая төг буюу 7,2 хувиар өслөө.


Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оныхоос 737,9 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 13,8 хувиар, тэтгэмжийн даатгалын сан 1,6 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оныхоос 7,2 хувиар өсөхөд тэтгэврийн даатгалын сан 10,9 хувиар, тэтгэмжийн даатгалын сан 4,8 хувиар, ҮОМШӨ-ний даатгалын сан 2,1 хувиар өссөн нь шууд нөлөөлөв. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэрт 12,5 мянган хүнд 10,8 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэмжид 549 хүнд 388,3 сая төгрөгийг олгосон байна.

Оны эхний 3 сард нийгмийн халамжийн сан болон хүний хөгжил сангаас давхардсан тоогоор 24,9 мянган хүнд 3832,9 сая төгрөгийн тэтгэмж хөнгөлөлт тусламж, хишиг олгосон байна. Нийгмийн халамж үйлчилгээгээр олгосон нийт мөнгөний 41,6 хувь нь нийгмийн халамжийн сангаас олгосон халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, хөнгөлөлт, 58,4 хувийг улсын төсвөөс олгосон тэтгэмж тусламж эзэлж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон мөнгөний 56,0 хувийг халамжийн тэтгэврээр, 28,1 хувийг нөхцөлт мөнгөн тэтгэмжээр, 15,9 хувийг ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон болон хүнс тэжээлийн хөнгөлөлт тусламжид зарцуулж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон, тэтгэвэр, тэтгэмжийн бүтэц




ГЭМТ ХЭРЭГ

Аймгийн хэмжээгээр 64 хүн гэмт хэрэгт холбогдож 145 гэмт хэрэг гарсны дотор хүний амь бие эрүүл мэндийн эсрэг хэрэг 53, өмчлөх эрхийн эсрэг 71, тээврийн хэрэгслийн

хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг 6, байгаль хамгаалах журмын эсрэг 5, бусад 10 хэрэг гарсан байна.

Гэмт хэргийн улмаас 7 хүн нас барж, 56 хүн гэмтэж бэртэн улс болон иргэдэд 271,5 сая төгрөгийн хохирол учирсан байна. Бүртгэгдсэн нийт хэргийн 13,1 хувийг бүлэглэж 8,9 хувийг согтуугаар үйлдсэн байгаа ба зөрчил гаргасан 124 хүнийг албадан саатуулж 35 хүнийг баривчилсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэрэгт холбогдогчийн тоо, жил бүрийн эхний 3 сарын байдлаар



Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлэхэд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 9,8 хувиар буюу 13 тохиолдлоор өссөний дотор хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 15,2 хувиар буюу 7 тохиолдлоор, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 7,6 хувиар буюу 5 тохиолдлоор тус тус өссөн байна.

Гэмт хэргийн гаралтыг сумдаар үзвэл Хангай суманд огт гараагүй, 18 болон түүнээс дээш насны арван мянган хүн амд ноогдох гэмт хэргийн тоогоор Жаргалант, Өндөрүлаан, Тариат, Чулуут сумд 0,4-0,8 хувьтай байгаа нь хамгийн бага байгаа бол Эрдэнэбулган сум 5,2 хувьтай, Хотонт, Батцэнгэл, Цэцэрлэг, Өлзийт сумд 2,8-3,3 хувьтай байгаа нь хамгийн их гэмт хэрэг гарсан байна.




ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО ЗАРЛАГА

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулан тооцсоноор 2018 оны эхний 3 сард аймгийн төсөвт 5826,9 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 6454,3 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 110,8 хувиар биелүүлсэн байна.

Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулахгүйгээр аймаг өөрөө 1256,3 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 1883,7 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн төлөвлөгөөг 149,9 хувиар биелүүллээ. Төсвийн орлогын төлөвлөгөөг бүх сумд 102,3 хувиас 11,8 дахин биелүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн орлогын бүтэц, хувиар



Орлогыг нэр төрлөөр нь үзвэл агнуурын нөөц ашигласны төлбөр, ойгоос хэрэглээгий мод түлээ ашигласны төлбөр, ус рашааны төлбөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжаас бусад нэрийн орлогуудыг 100,0 хувиас 5,9 дахин биелүүлсэн байна.


Аймгийн төсвийн орлогын 70,8 хувийг тусламжийн орлогоор, 19,8 хувийг орлогын албан татвараар, 1,3 хувийг өмчийн татвараар, 0,7 хувийг тусгай зориулалтын орлогоор /АТӨЯХэрэгслийн/, 3,4 хувийг бусад албан татвараар, 2,5 хувийг татварын бус орлогоор, 1,5 хувийг хөрөнгийн орлогоор бүрдүүлж байна.

Улсын төвлөрсөн төсөвт аж ахуй нэгжийн орлогын татвараар 65,7 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараар 426,9 сая төгрөг, агаарын бохирдлын төлбөрөөр 3,3 сая төгрөг бүгд 495,9 сая төгрөгийг шилжүүллээ.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлагын хэмжээ 14030,1 сая төгрөг байгаагийн 53,7 хувийг цалин хөлсөнд, 6,4 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 39,9 хувийг бараа үйлчилгээ болон бусад зардалд зарцуулжээ. Эдийн засгийн салбараар харвал 31,4 хувийг нийтийн ерөнхий

үйлчилгээнд, 57,4 хувийг боловсролын салбарт, 10,0 хувийг эрүүл мэндийн салбарт, 0,7 хувийг барилга хот байгуулалтын салбарт, 0,5 хувийг бусад салбарт зарцууллаа.

**Орон нутгийн төсвийн байгууллагын
нийт зарлагын бүтэц, хувиар**



МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Манай аймагт арилжааны 4 банкны салбар иргэд аж ахуй нэгж байгууллагуудад үйлчилгээ үзүүлж байна. Монгол банкны мэдээгээр арилжааны банкууд монгол банкнаас зузаатгалаар 6716.0 сая төгрөгийг авч 5.6 тэрбум төгрөгийг гүйлгээнээс эргүүлэн татсан байна.

Оны эхний 3 сард банкууд 18.1 мянган иргэд, аж ахуй нэгжид 34.9 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл, олгосон зээлийн хэмжээ, жил бүрийн эхний 3 сарын байдлаар сая.төг



Өнгөрсөн оны мөн үеийнхтэй зэрэгцүүлэхэд иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 17.2 хувиар, олгосон зээлийн хэмжээ 3,2 хувиар өссөн байна. Харин анхаарал хандуулах зээлийн хэмжээ 63.4 хувиар, чанаргүй зээлийн хэмжээ 26,6 хувиар нэмэгдсэн байна.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2018 оны 3 дугаар сард бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх сарынхаас 0,3 хувиар, өнгөрсөн оны мөн үеийнхээс 3,7 хувиар, 2017 оны 12-р сарынхаас 1,9 хувиар, 2015 оны 3-р сарынхаас 12,5 хувиар тус тус өссөн байна.

Өнгөрсөн 2 дугаар сартай зэрэгцүүлэхэд хэрэглээний сагсанд авсан 238 нэрийн бараа үйлчилгээний үнэ тарифын 11,3 хувийнх нь өсч, 3,4 хувийнх нь үнэ буурч 85,3 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Тухайлбал өмнөх сарынхаас хонь, ямаа, адууны мах, өөхөн тос, хорхой ааруул, сонгино, төмс, лууван, чинжүү зэргийн үнэ 0,1-11,5 хувиар буурч харин үхрийн мах, далайн байцаа, сүү тараг, үзэм компот, пиво, хүүхдийн оймс, сурагчийн дэвтэр, мотоцикл зэргийн үнэ 0,5 – 12,6 хувиар нэмэгдсэн байна.

Харин өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэхэд 5,0 хувийнх нь буюу 12 нэрийн бараа үйлчилгээний үнэ буурч, 31,9 хувийнх нь буюу 76

нэрийн бараа үйлчилгээний үнэ тариф өсч, 63,1 хувийнх нь үнэ тогтвортой байна.


Өнгөрсөн оны мөн үеийнхээс жигнэмэг, хонь, ямаа, үхрийн мах, савласан сүү, өөхөн тос, байцаа, улаан лооль, чинжүүний үнэ 1,4-25,0 хувиар буурч харин гурил, хорхой ааруул, масло, улаан лооль, шоколад, зайрмаг, исгэгч, цагаан будаа, сурагчийн дөрвөлжин шугамтай дэвтэр, эрэгтэй эмэгтэй хүний гадуур, дотуур хувцас, гутал, ботинк, саван, цахилгааны үнэ, хуруу зай, бүх төрлийн шатахуун зэрэг барааны үнэ 0,5- 29,2 хувиар нэмэгдсэн байна.



ХӨДӨӨ АЖ АХУЙ

4 дүгээр сарын 1-ний байдлаар оны эхний хээлтэгч малын 12,9 хувь нь буюу 287,3 мянган эх мал төллөж гарсан төлийн 96,2 хувь нь буюу 276,2 мянган төл бойжиж байна. Төл бойжилтыг малын төрлөөр үзвэл гарсан ботго 100,0 хувь, унаганы 90,8 хувь, тугалын 93,3 хувь хурганы 97,5 хувь, ишигний 94,0 хувь нь бойжиж байна.

Сумдаас Өгийннуур, Эрдэнэбулган, Эрдэнэмандал, Төвшрүүлэх, Хайрхан сумд гарсан төлөө 99,0 - 100,0 хувиар бойжуулж байна.




Өнгөрсөн оны мөн үеийнхээс аймгийн дүнгээр төллөсөн эх мал 53,1 хувиар, бойжиж байгаа төлийн тоо 52,8 хувиар бага, төлийн хорогдол 41,3 хувиар бага байна.

Эхний улирлын байдлаар оны эхний мал 98,0 хувиар онд орж оны эхний малын 2,0 хувь буюу 108,1 мянган том мал хорогдов. Хорогдсон малын 9,0 хувийг адуу, 19,0 хувийг үхэр, 36,7 хувийг хонь, 35,3 хувийг ямааны хорогдол эзэлж байна.

Сумдаас Хотонт, Хашаат, Цахир, Өгийнуур, Цэнхэр, Хайрхан, Батцэнгэл сумдын оны эхний малын 2,1- 4,9 хувь нь, Хангай, Чулуут, Ихтамир, Булган, Өлзийт сумдын оны эхний малын 1,0- 1,7 хувь нь, бусад сумдын малын 0,3-0,9 хувь нь хорогдсон дүнтэй байна.

Зүй бусаар хорогдсон малын тоо бүтэц, төрлөөр



2018 онд манай аймаг ойгоос 96,6 мянган м3 галын түлээ, 11,1 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 107,7 мянган м3 мод авч ашиглахаар баталсанаас оны эхний 3 сард 9,7 мянган м3 галын түлээ, 1,7 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 11,4 мянган м3 мод бэлтгэж хэрэглэсэн байна. Бэлтгэсэн модны

гоожингийн орлогоор 47,6 сая төгрөг төсвийн орлогод оруулсан байна.



АЖ ҮЙЛДВЭР

Үйлдвэрийн газрууд 2018 оны эхний 3 сард оны үнээр 1845,5 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж борлуулсан нь өнгөрсөн оныхоос 8,6 хувиар илүү байна. Зэрэгцүүлэх үнээр үнэлснээр 664,0 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 10,3 хувиар их байна.

Нийт үйлдвэрлэлтийн 6,4 хувийг хүнс ундааны, 0,7 хувийг хэвлэлийн, 71,9 хувийг дулааны эрчим хүчний, 13,4 хувийг усан хангамж, 2,0 хувийг модон эдлэлийн, 5,4 хувийг гутал хувцасны, 0,2 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Гол нэрийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, бууз, хэрчсэн гурил, түгээсэн цэвэр ус, дулаан, гэрийн модон тавилгын үйлдвэрлэл 0,6- 225,0 хувиар нэмэгдлээ. Харин монгол болон савхин гутал, хүснэгт маягт, монгол дээл үйлдвэрлэлийн хэмжээ 5,1 – 35,7 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлт, бүтэц, хувиар



Тээврийн байгууллагууд 14,0 мянган зорчигч, 1,9 мянган тонн ачаа тээвэрлэн 6,5 сая хүн км, 0,9 сая ткм ажил гүйцэтгэн 59,3 сая төгрөгийн орлоготой ажиллаа. Өнгөрсөн оны мөн үеийнхээс зорчигч, зорчигч эргэлт, ачаа, эргэлтийн хэмжээ 9,1-13,7 хувиар нэмэгдлээ.

Холбооны байгууллагууд 396 телефон цэг улс, хот хоорондын телефон, интернет, телевизийн үйлчилгээгээр байгууллага иргэдэд үйлчилж сумдад 7 хоногт 1-2 удаа шуудан хүргэж нийт 73,5 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 4,1 хувиар буурсан байна.



ЦАГ УУРЫН БАЙДАЛ

3 дугаар сард агаарын дундаж температур -4,7-оос 0,7 хэм байсан бөгөөд хамгийн их дулаан Хашаат, Өгийнуур, Өлзийт, Батцэнгэл сумдад 20,0 – 21,0 хэм хүрч байсан бол хамгийн хүйтэн нь Өндөрүлаан, Тариат, Батцэнгэл, Хангай, Чулуут сумдад -26,0-аас -28,0 хэмд хүрч хүйтэрч байсан байна.

Энэ сард Эрдэнэбулган, Батцэнгэл, Чулуут, Булган, Төвшрүүлэх сумдын нутгаар 3,3- 7,5 мм цас орсон нь хамгийн их тундастай байгаа бол Хангай, Өндөрүлаан, Тариат, Эрдэнэмандал сумдад 0,4 – 0,9 мм хур тундас орсон нь хамгийн бага байна.

Статистикийн хэлтэс
2018.04.10

www.1212.mn
СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛИЙН
НЭГДСЭН САН

www.1212.mn сайтын
Харалтгүй байдлаар
бүртгүүлснээр цахим
хаягаар тогтмол
авч болно.

1900-1212
Лавлах утас

Монstat ezStat
апликайшн

@statistic_mn
Статистик
мэдээлэл

Үндэсний Статистикийн
Хорооны
НОМЫН САН

Онлайн лавлах
мессенжер
8:30-17:30



2018 онд мөрдөх “Хүн амын амьжиргааны доод түвшин”

